



**УВС АЙМАГ ДАХЬ СУМ ДУНДЫН
АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН
ШҮҮГЧДИЙН ЗӨВЛӨГӨӨНИЙ ТОГТООЛ**

2025 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 2025/ШЗТ/26

Улаангом сум

Эрүүгийн болон зөрчлийн хэрэг, гомдол, санал, хүсэлт, дүгнэлт хүлээн авах,
хуваарилах, хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар
томилох журмыг шинэчлэн батлах тухай

Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн Шүүгчдийн зөвлөгөөнөөр эрүүгийн болон зөрчлийн хэрэг, санал, гомдол, хүсэлт, дүгнэлт хүлээн авах, хуваарилах, хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох журам шинэчлэн батлах тухай асуудлыг хэлэлцээд

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2.5, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1, 2, 3.3 дугаар зүйл, Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нийтлэг журам 1.1-т тус тус заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Эрүүгийн хэргийг дагнан шийдвэрлэх шүүгчдэд эрүүгийн болон зөрчлийн хэрэг, санал, хүсэлт, гомдол, дүгнэлт хуваарилах дарааллыг сугалаагаар:

1.1. Эрүүгийн хэргийг:

- Шүүгч Б.Мөнхзаяа;
- Ерөнхий шүүгч Б.Гансүх гэх;

1.2. Зөрчлийн хэрэг, гомдол, дүгнэлтийг:

- Шүүгч Б.Мөнхзаяа;
- Ерөнхий шүүгч Б.Гансүх гэх;

1.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх /Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 37 дугаар бүлэг/-тэй холбоотой санал, дүгнэлтийг:

- Шүүгч Б.Мөнхзаяа;
- Ерөнхий шүүгч Б.Гансүх гэх;

1.4. Шийтгэврийн биелэлтийг баталгаажуулах, гүйцэтгэх хуудас олгох, хуулиар шүүгч хянан шийдвэрлэхээр тогтоосон бусад гомдол, санал, хүсэлтийг:

- Шүүгч Б.Мөнхзаяа;
- Ерөнхий шүүгч Б.Гансүх гэх тойрог тус тус үүсгэж, уг дарааллыг эрүүгийн хэргийн нэгдсэн системд байршуулахыг мэдээллийн технологийн мэргэжилтэн /Д.Цэвээндорж/-д даалгасугай.

2. Шүүх бүрэлдэхүүн томилох

851250215

2.1. Эрүүгийн хэргийг дагнан шийдвэрлэх шүүгч нар эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнд тогтоолын 1.1-т тогтоосон дарааллаар оролцоно. Бүрэлдэхүүн хүрэлцэхгүй тохиолдолд иргэний хэрэг дагнан шийдвэрлэх шүүгч нараас сугалаагаар тогтоосон:

- Шүүгч Л.Дэлгэрцэцэг;
- Шүүгч П.Болор;
- Шүүгч Я.Урнаа гэх дарааллаар оролцуулсугай.

3. Эрүүгийн хэргийг дагнан шийдвэрлэх бүх шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарсан, эсхүл тэдгээрийн эзгүй /ээлжийн амралттай, эсхүл ажлын таван өдрөөс дээш өвчтэй, чөлөөтэй, томилолттой тохиолдолд/-д иргэний хэргийг дагнан шийдвэрлэх шүүгчдэд эрүүгийн болон зөрчлийн хэрэг, санал, хүсэлт, гомдол, дүгнэлт хуваарилах дарааллыг сугалаагаар:

- Шүүгч Я.Урнаа;
- Шүүгч Л.Дэлгэрцэцэг;
- Шүүгч П.Болор гэх тойрог үүсгэсүгэй.

4. Хэргийг бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэх тохиолдолд тухайн хэрэг хуваарилагдсан шүүгчээр шүүх хуралдааныг даргалуулсугай.

5. Тодорхой хэргийг хянан хэлэлцэх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй болсон тохиолдолд адил шатны өөр шүүхийн дээд шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн шийдвэрээр шүүгч томилуулж шүүх бүрэлдэхүүнд оролцуулахаар тогтоосугай.

6. Шүүгч адил шатны өөр шүүхийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнд орох тохиолдолд сугалаагаар тогтоосон:

- Шүүгч П.Болор;
- Ерөнхий шүүгч Б.Гансүх;
- Шүүгч Л.Дэлгэрцэцэг;
- Шүүгч Б.Мөнхзаяа;

- Шүүгч Я.Урнаа гэх дарааллыг баримтлах бөгөөд бүрэлдэхүүнд орох шүүгч нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас оролцох боломжгүй тохиолдолд дараагийн шүүгчийг томилуулан оролцуулсугай.

7. Хэрэг хуваарилах журам батлах

7.1. “Эрүүгийн болон зөрчлийн хэрэг, гомдол, санал, хүсэлт, дүгнэлт хүлээн авах, хуваарилах, хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох журам”-ыг хавсралтаар баталсугай.

7.2. “Эрүүгийн болон зөрчлийн хэрэг, гомдол, санал, хүсэлт, дүгнэлт хүлээн авах, хуваарилах, хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох журам”-ыг Увс аймгийн шүүхийн цахим хуудсанд олон нийтэд нээлттэйгээр байршуулахыг мэдээлэл, технологийн мэргэжилтэн /Д.Цэвээндорж/-д даалгасугай.

8. Бусад

8.1. Энэхүү тогтоолыг 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн даган мөрдөхөөр тогтоож, “Эрүүгийн болон зөрчлийн хэрэг, гомдол, хүсэлт, өргөдөл хүлээн авах, хуваарилах, хэрэг маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох журам өөрчлөн батлах тухай” 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 2025/ШЗТ/09 дугаартай тогтоол болон тус тогтоолын хавсралтыг тус өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

8.2. Уг тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий шүүгч /Б.Гансүх/, зохион байгуулалт, биелэлтийг хангаж ажиллахыг Тамгын газрын дарга /Л.Баттулга/-д тус тус даалгасугай.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ
ШҮҮГЧИД


Б.ГАНСҮХ

П.БОЛОР

Л.ДЭЛГЭРЦЭЦЭГ

Б.МӨНХЗАЯА

Я.УРНАА





Эрүүгийн болон зөрчлийн хэрэг, гомдол, санал, хүсэлт, дүгнэлт хүлээн авах, хуваарилах, хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох журам

Нэг: Нийтлэг үндэслэл

1.1. Эрүүгийн болон зөрчлийн хэрэг, гомдол, санал, хүсэлт, дүгнэлт хүлээн авах, хуваарилах, хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг томилоход энэхүү “журам”-ыг баримтална.

1.2. Шүүхэд хүлээн авч байгаа эрүү болон зөрчлийн хэрэг, гомдол, эсэргүүцэл, хүсэлт, дүгнэлтийг мэдээлэл лавлагааны мэргэжилтэн энэхүү журмаар тогтоосон цагт “Прокуророос шүүхэд шилжүүлсэн хэргийг хүлээн авах бүртгэл”, “Прокуророос шилжүүлсэн Зөрчлийн хэрэг хүлээн авсан бүртгэл”, “Анхан шатны шүүхэд гомдол, эсэргүүцэл, өргөдөл, хүсэлт хүлээн авсан бүртгэл”-ийн дагуу шалгаж, ирсэн цаг, минутын дарааллаар хүлээн авсан тэмдэглэгээ хийнэ.

1.3. Баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээтэй холбогдох санал /мөрдөгчийн тогтоол/, хүсэлт, гомдлыг уг асуудлыг шийдвэрлэх шүүгчийн туслах шөнийн цагаас бусад хугацаанд хүлээн авч, ирсэн цаг, минутыг тэмдэглэж, цахим системд бүртгэж, хянан шийдвэрлэх шүүгчид даруй танилцуулна.

1.4. Таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой болон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд шүүгчийн зөвшөөрлөөр хийгдэх ажиллагааг Ерөнхий шүүгчээс бусад шүүгч шийдвэрлэнэ.

1.5. Баривчлах болон таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой санал, хүсэлтийг шүүгч Б.Мөнхзаяа шийдвэрлэнэ. Тухайн шүүгч эзгүй /өвчтэй, чөлөөтэй, томилолттой/-д “Эрүүгийн болон зөрчлийн хэрэг, гомдол, санал, хүсэлт, дүгнэлт хүлээн авах, хуваарилах, хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох журмыг шинэчлэн батлах тухай” тогтоол /цаашид “тогтоол” гэх/-ын 3-т заасан дарааллын дагуу бусад шүүгч нар тойргоор хянан шийдвэрлэнэ.

1.6. Таслан сэргийлэх арга хэмжээг хариуцсан ээлжийн шүүгч ажлын бус цагаар, долоо хоногийн амралтын өдөр болон нийтээр амрах баярын өдрөөр 06:00 цагаас 22:00 цаг хүртэл зайлшгүй тохиолдолд ажиллана.

Хоёр. Эрүүгийн хэрэг хуваарилах

2.1. Мэдээлэл лавлагааны мэргэжилтэн эрүүгийн хэргийг ажлын өдөрт 08:00 цагаас 16:00 цагийн хооронд хүлээн авч эрүүгийн хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн системээс сугалаагаар тогтоосон тойрог дотор санамсаргүй тохиолдол /цаашид “ердийн журмаар” гэх/-оор хуваарилна.

2.2. Анхан шатны шүүхээс прокурорт буцаасан эрүүгийн хэргийг буцаасан шүүгчид хуваарилна. Хэргийг буцаасан шүүгч эзгүй /ажлын 5 өдрөөс дээш өвчтэй, чөлөөтэй гэх мэт ажил үүргээ гүйцэтгээгүй тохиолдол/-д ердийн журмаар хуваарилна.

2.3. Эрүүгийн хэргийг нэгтгэх тохиолдолд хөнгөнийг хүндэд нь багтаах журмаар нэгтгэж, хүнд хэрэг нь хуваарилагдсан шүүгч шийдвэрлэнэ. Хоёул хөнгөн эсвэл хүнд

хэргийг нэгтгэх тохиолдолд эхэлж эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан хэрэгт нэгтгэж, тухайн хэргийг хүлээж авсан шүүгч шийдвэрлэнэ.

2.4. Эрүүгийн хэргийг тусгаарласан тохиолдолд тусгаарлагдсан хэргийг ердийн журмаар шүүгчид хуваарилна.

2.5. Давж заалдах болон хяналтын журмаар хянаад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль зөрчсөн үндэслэлээр хүчингүй болгож анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцаасан эрүүгийн хэргийг урьд хянан шийдвэрлэсэн шүүгчид хуваарилна.

2.6. Давж заалдах болон хяналтын журмаар хянаад:

- Шүүхийн тогтоол /цагаатгах, шийтгэх/-д заасан үндэслэл нь хэргийн бодит байдалд нийцээгүй;

- Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн үндэслэлээр хүчингүй болгож анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцаасан эрүүгийн хэргийг урьд хэргийг шийдвэрлэсэн шүүгчээс бусад шүүгчид эрүүгийн хэргийн нэгдсэн системээс хуваарилна. Эрүүгийн хэргийг дагнан шийдвэрлэх өөр шүүгч байхгүй тохиолдолд энэ заалт хамаарахгүй.

2.7. Харьяалал тогтоож ирүүлсэн болон шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хүчингүй болж ирсэн, шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг татгалзан гаргасан, шүүгч өөрөө татгалзан гарсан хэргийг ердийн журмаар хуваарилна.

2.8. Шүүх бүрэлдэхүүнд томилогдсон шүүгч үргэлжлүүлэн оролцох боломжгүй болсон тохиолдолд тогтоолын 2-т заасан тойргийн дарааллаар шүүх бүрэлдэхүүнд оролцох дараагийн шүүгчийг томилж оролцуулна.

2.9. Иргэний хэрэг дагнан шийдвэрлэх шүүгчид эрүүгийн хэрэг хуваарилах тохиолдолд эрүүгийн хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн системээс сугалаагаар тогтоосон тойрог дотор санамсаргүй тохиолдол /цаашид "ердийн журмаар" гэх/-оор хуваарилна.

Гурав: Зөрчлийн хэрэг хуваарилах

3.1. Мэдээлэл лавлагааны мэргэжилтэн зөрчлийн хэргийг ажлын өдөрт 08:00 цагаас 16:00 цагийн хооронд; прокурорын дүгнэлт, шийтгэлийн хуудаст гаргасан оролцогчийн гомдлыг ажлын өдөрт 08:00 цагаас 17:00 цагийн хооронд тус тус хүлээн авч, ирсэн цаг, минутын дарааллаар хүлээн авсан тэмдэглэгээ хийж, сугалаагаар үүсгэсэн тойргийн дарааллаар эрүүгийн хэргийг дагнан шийдвэрлэх шүүгчид хуваарилна.

3.2. Иргэний хэрэг дагнан шийдвэрлэх шүүгчид зөрчлийн хэрэг хуваарилах тохиолдолд тогтоолын 3-т заасан тойргийн дарааллаар дээрх журмын дагуу хуваарилна.

3.3. Давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцаасан зөрчлийн хэргийг энэхүү журмын 3.1-т зааснаар хуваарилна.

3.4. Шүүгч томилолтоор ажиллах, сургалтад оролцох тохиолдолд явахын өмнөх өдрөөс ажилд орох хүртэл; өвчтэй, чөлөөтэй тохиолдолд тухайн өдрөөс ажилд орох хүртэл зөрчлийн хэрэг хуваарилахгүй.

Дөрөв: Дүгнэлт, гомдол, хүсэлт хуваарилах

4.1. Давж заалдах болон хяналтын шатны шүүхэд гомдол, эсэргүүцэл гаргах хугацаа сэргээлгэх хүсэлтийг тухайн хэргийг шийдвэрлэсэн шүүгчид хуваарилна. Тухайн шүүгч, эсхүл эрүүгийн хэргийг дагнан хянан шийдвэрлэх бүх шүүгч эзгүй

(ажлын 5 өдрөөс дээш томилолттой, өвчтэй, чөлөөтэй) тохиолдолд тогтоолын 3-т заасан дарааллаар хуваарилна.

4.2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа хэрэгт холбогдуулан гаргасан гомдол, хүсэлтийг тухайн хэрэг хянан шийдвэрлэх шүүгчид хуваарилна.

4.3. Шүүхийн шийдвэрийг биелүүлэхтэй холбоотой буюу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 37.5-37.12 дугаар зүйлд заасны дагуу ирүүлсэн гомдол, хүсэлт, дүгнэлтийг тогтоолын 1.3-т заасан дарааллаар гараар хуваарилна. Эрүүгийн хэргийг дагнан хянан шийдвэрлэх бүх шүүгч эзгүй (ажлын 5 өдрөөс дээш томилолттой, өвчтэй, чөлөөтэй) тохиолдолд тогтоолын 3-т заасан дарааллаар бусад шүүгчдэд хуваарилна.

5.1. Шүүгч ээлжийн амралт, чөлөө, томилолт (15 буюу түүнээс дээш хоног) эхлэхээс хуанлийн 14 хоногийн өмнө ердийн журмаар шийдвэрлэх эрүүгийн хэрэг хуваарилахыг;

- хуанлийн 7 хоногийн өмнө хялбаршуулсан журмаар шийдвэрлэх хэрэг, гомдол, хүсэлт, дүгнэлт, зөрчлийн хэрэг хуваарилахыг тус тус зогсоож, ажилд орсон өдрөөс эхлэн хэрэг хуваарилна.

5.2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шуурхай тасралтгүй явуулах зорилгоор шүүгч ээлжийн амралт эдлэх, чөлөөтэй, өвчтэй тохиолдолд түүний хянан шийдвэрлэж байгаа санал, гомдол, дүгнэлт, хэргүүдийг тухай бүр шүүгчдийн зөвлөгөөнөөр хэлэлцэж өөр шүүгчид шилжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

5.3. Энэхүү журмаар зохицуулаагүй эрүүгийн болон зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой бусад асуудлыг тухай бүр нь шүүгчдийн зөвлөгөөнөөр шийдвэрлэнэ.

УВС АЙМАГ ДАХЬ СУМ ДУНДЫН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН
ШҮҮГЧДИЙН ЗӨВЛӨГӨӨН